



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

**2018 ОНЫ 07 ДУГААР САРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2018 ОН**

АГУУЛГА

НЭГ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

1.1. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаар	3
1.2. Өргөдөл, гомдол түүний шийдвэрлэлтийн талаар	4
1.3. Сургалт, мэдээллийн талаар	4
1.4. Санхүү, хөрөнгө оруулалтын талаар	4
1.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар.....	5
1.6. Хяналт шалгалтын талаар	6

ХОЁР. САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР:

2.1. Хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох талаар.....	7
2.2. Хууль, Шүүхийн байгууллагад төлөөлөн оролцсон ажлын талаар	7

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗАРТ ТАВЬЖ ШИЙДВЭРЛҮҮЛСЭН БОЛОН ШИЙДВЭРЛҮҮЛЭХАСУУДАЛ:

8

ДӨРӨВ. САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

8

4.1. Авто замын талаар	8
4.2. Авто тээврийн талаар	10
4.3. Төмөр замын талаар	10
4.4. Агаарын тээврийн талаар	11

ТАВ. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

11

ЗУРГАА. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

12

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2018 ОНЫ 07 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ТОВЧ ТАЙЛАН

2018 оны 08 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Зам, тээврийн хөгжлийн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, яамны үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээний бодлого, зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд яамны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

1.1. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаар:

Зам, тээврийн хөгжлийн яамны албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журам, стандартын дагуу хөтлөн явуулж, яаманд ирсэн хариутай бичигт бүртгэл хяналтын карт хөтөлж, шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж, хариу өгөх хугацаа хэтэрсэн бичгийн мэдээг 7 хоног тутам гаргаж удирдлагуудад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Тус яаманд 2018 оны 07 дугаар сард нийт 907 бичиг ирснээс хариутай 444 бичиг, хариугүй 463 бичиг, шийдвэрлэсэн 230, 13627,5 хуудас бичгийг сканердаж бүртгэл мэдээллийн санд оруулав.

Ирсэн бичгийг удирдлагын цохолтоор Бодлого, төлөвлөлтийн газарт-153, Төрийн захиргааны удирдлагын газарт-253, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт-185, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт-63, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт-141, Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс-41, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт-72 шилжүүлсэн байна.

Ирсэн бичгийг байгууллагаар нь ангилж үзвэл: Монгол Улсын Засгийн газраас-5, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас-12, УИХ-ын гишүүн, байнгын хороодоос-40, яамдуудаас-128, Элчин сайдын яамдаас-2, Авилгатай тэмцэх газраас-5, Төрийн албаны зөвлөлөөс -2, аймаг, орон нутаг-45, дүүрэг, хорооноос-9, шүүх, цагдаагийн байгууллагаас-20, төсөл хэрэгжүүлэх нэгжүүдээс-49, харьяа байгууллагаас-90, компаниас-185, холбоодоос-21, бусад аж ахуйн нэгж, байгууллагаас-315 бичиг ирсэн байна.

Агуулгаар нь ангилбал: Санал авах-72, хүсэлт гаргах, хүргүүлэх, уламжлах-95, гүйцэтгэл, санхүүжилт хүссэн-51, тусгай зөвшөөрөл-16, шагнал-92, хариу ирүүлсэн-124, биелэлт, тайлан, мэдээ ирүүлсэн-89, мэдээлэл авах-3, асуудал шийдвэрлүүлж дэмжлэг хүссэн-22, бусад 313 бичиг тус тус байна.

Яамнаас гадагш-409 албан бичиг явуулж 2658 хуудас сканердаж able программд оруулав.

Явуулсан бичгийг газар тус бүрээр ангилбал: Бодлого төлөвлөлтийн газар -106, Төрийн захиргааны удирдлагын газар-101, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар- 129, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар-40,

Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар-61, Хяналт - шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар-23, Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс-30 бичиг тус тус байна.

1.2. Өргөдөл, гомдол түүний шийдвэрлэлтийн талаар:

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг цаг тухайд нь цахим болон дэвтрээр бүртгэн карталж удирдлагад танилцуулан холбогдох газар, хэлтэс, мэргэжилтэнд хувиарлан шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллаж байна.

2018 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс 2018 оны 08 дугаар сарын 31-ний байдлаар яамны хэмжээнд иргэд, албан хаагчдаас нийт 25 өргөдөл, гомдол ирсэнийг удирдлагад танилцуулан цохолт хийлгүүлж холбогдох албан тушаалтанд хуваарилан ажиллалаа. Шийдвэрлэж хариу өгсөн 17, хяналтад байгаа 5, хугацаа хэтэрсэн 2 өргөдөл, гомдол, шийдвэрлэлтийн хувь 70.83 хувьтай байна.

Дээрх өргөдөл, гомдол нь ээлжийн амралт олгуулах, цалинтай, цалингүй чөлөө хүссэн зэрэг агуулгатай байна.

Иргэд болон албан хаагчдын санал, хүсэлтийг хүлээн авах “Санал хүсэлт”-ийн хайрцгийг 1 давхарт байрлуулан санал хүсэлтийг бүртгэх, хүлээн авах албан тушаалтныг томилон тогтмол ажиллуулж байна.

1.3. Сургалт, мэдээллийн талаар:

Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтнүүдийн ур чадвар, мэргэжлийг дээшлүүлэх, чадавхжуулах зорилгоор тус газрын 2 хүнийг гадаад хэлний сургалтад хамруулаад байна.

1.4. Санхүү, хөрөнгө оруулалтын талаар:

Сайдын багцын харьяа төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог Сангийн сайдын батлагдсан төсвийн зарцуулалтын эрхийн баталгааг үндэслэн 07 дугаар сард нийт 194 ширхэг 3,9 тэрбум төгрөгийн зарлагын гүйлгээг анхан шатны баримттай тулган шалгаж төсвийн тухай хууль болон холбогдох журам, дүрмийн дагуу төлбөр тооцоог хурдан шуурхай, үнэн зөв хийж гүйцэтгэн хянан баталгаажуулсан.

Хөрөнгө оруулалтын таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний мэдээ, цалингийн зардлаас бусад таван саяас дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээ Засгийн газрын шилэн дансны цахим хуудсанд байршуулсан.

Норм, нормативын санд 2018 оны 07 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар авто зам, замын байгууламжийн барилгын ажлын санхүүжилт болон норм, стандарт, техникийн баримт бичиг борлуулснаас нийт 226,218,604 төгрөгийн орлого орж, зөвлөх үйлчилгээний 2 ажлын 79,270,210 төгрөгийн зарлага гарсан.

Албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ажлын байрны бичиг хэргийн материалыг сар бүр захиалгын хуудсын дагуу захиалан тарааж байна. 2018 оны 07 дугаар сарын 31-ны байдлаар бичиг хэргийн зардал 16,758,575 төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх бараа материалын зардалд 7,801,738 төгрөг, шуудан, холбоо, интернетийн төлбөрт 9,862,642.39 төгрөгийн зардлууд зарцуулагдаад байна. Мөн бусад техник хэрэгслээр цаг тухай бүр ханган ажиллаж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих 11 төсөл, арга хэмжээний 9,2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Сангийн яамнаас эрх нээсний дагуу гүйцэтгэгчийн дансанд олгосон. Захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний дагуу 17 төсөл, арга хэмжээний 6,4 тэрбум төгрөгийн баталгаат хугацааны барьцаа хөрөнгийг Сангийн яамнаас эрх нээсний дагуу чөлөөлж, гүйцэтгэгчийн дансанд олгосон.

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст сар бүр тогтсон хугацаанд нийгмийн даатгалын тайланг гарган тушааж байна. Албан хаагчдын жирэмсний тэтгэмж, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн тооцоог гаргаж, нийгмийн даатгалын хэлтсээс нэхэмжлэн, дансанд орсон тухай бүр албан хаагчдад тооцож олгож байгаа болно. 2018 оны 07 дугаар сарын 31-ний байдлаар нийт 17,153,271 төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж болон жирэмсэн амаржсаны тэтгэмжийг тооцсоны дагуу 38 албан хаагчид олгосон.

1.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар:

Зам, тээврийн хөгжлийн яамны 6 газар, 1 хэлтэс болон харьяа 7 байгууллагуудын үйл ажиллагааны хэрэгжилтэд 2018 оны хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох тайланг яамны удирдлагад танилцуулан баталгаажуулаад байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 269 дүгээр тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2018-2020 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд;
2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төсвийн шууд захирагчтай Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын 2018 онд байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, газрын үйл ажиллагаанд;
3. Зам, тээврийн хөгжлийн яамны Төсвийн шууд захирагчтай Автозамын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын 2018 онд байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, газрын үйл ажиллагаанд;
4. Зам, тээврийн хөгжлийн яамтай “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын захирлын 2018 онд байгуулсан “Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ”-ний биелэлт болон газрын үйл ажиллагаанд;
5. “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т гэрээний үндсэн дээр шилжүүлэн гүйцэтгүүлж буй ажил, үйлчилгээний хэрэгжилт болон тус газрын үйл ажиллагаанд;
6. “Сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 02 дугаар албан даалгавраар “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-т өгсөн үүргийн биелэлт;
7. “Сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 02 дугаар албан даалгавраар “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т өгсөн албан даалгаврын биелэлт;
8. “Автотээврийн салбарын ажил, үйлчилгээг сайжруулах тухай” Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 02 дугаар албан даалгаврын биелэлтэд эхний

хагас жилийн байдлаар тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгч, зөвлөмжөөр хангав.

Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр Зам, тээврийн хөгжлийн сайдад өгсөн үүрэг даалгаврыг үндэслэн улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкнаас Засгийн газарт шилжүүлсэн Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх /Авто замын барилгын 53 төсөл, арга хэмжээ, авто замын хяналтын 16 төсөл, арга хэмжээ, авто замын зургийн 12 төсөл, арга хэмжээ, гүүрийн барилгын 5 төсөл, арга хэмжээ, төмөр замын барилгын 4 төсөл, арга хэмжээ/ нийт 90 төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалт, төсөвт өртөг, хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэсэн ажлын чанар, хэрэгжилт болон хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн эсэхэд дүгнэлт гарган Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2018 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 01/3244 тоот албан бичгээр хүргүүлсэн.

1.6. Хяналт шалгалтын талаар:

A0501 дугаартай Улаанбаатар-Өндөрхаан чиглэлийн 157 км авто замд гарсан зөхчил дутагдлыг арилгуулахаар 2018.07.10-ны өдрийн 038-07-067/25 дугаартай Авто замын хяналтын улсын байцаагчийн албан шаардлагыг “Харгуй” ТӨХК-д хүргүүлсэн.

Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 143 км хатуу хучилттай авто замын III хэсгийн 13.32 км авто замд комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг дутуу гүйцэтгэн уг замд гарсан зөрчил дутагдлыг арилгуулах 2018.07.10-ны өдрийн 038-07-067/26 дугаартай Авто замын хяналтын улсын байцаагчийн албан шаардлагыг “Хансуун зам” ХХК-д хүргүүлсэн.

A2001 дугаартай Өндөрхаан-Баруун-Урт чиглэлийн 161.9 км, A2002 дугаартай Баруун-Урт-Бичигт чиглэлийн 278.2 км сайжруулсан болон ердийн хөрсөн зам, A2201 дугаартай Баруун-Урт-Чойбалсан чиглэлийн 16 км хатуу хучилттай авто замуудад гарсан зөрчил дутагдлыг арилгуулахаар 2018.07.10-ны өдрийн 038-07-067/27 дугаартай Авто замын хяналтын улсын байцаагчийн албан шаардлагыг “Талын зам” ТӨХК-д хүргүүлсэн.

Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 143 км хатуу хучилттай авто замын IV хэсгийн 27.98 км авто замд комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг дутуу гүйцэтгэн уг замд гарсан зөрчил дутагдлыг арилгуулах 2018.07.10-ны өдрийн 038-07-067/28 дугаартай Авто замын хяналтын улсын байцаагчийн албан шаардлагыг “Насны зам” ХХК-д хүргүүлсэн.

Жаргалхаан-Чингис хот чиглэлийн 100 км хатуу хучилттай авто замын их, засвар шинэчлэлт хийсэн 17 км авто замд комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг дутуу гүйцэтгэн уг замд гарсан зөрчил дутагдлыг арилгуулах 2018.07.10-ны өдрийн 038-07-067/29 дугаартай Авто замын хяналтын улсын байцаагчийн албан шаардлагыг “Наранбулагхан” ХХК-д хүргүүлсэн.

A0502 дугаартай Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 160 км, A2201 дугаартай Баруун-Урт-Чойбалсан чиглэлийн 88 км, A-23 дугаартай Чойбалсан-Хавирга чиглэлийн 60.39 км сайжруулсан, ердийн хөрсөн болон хатуу хучилттай авто замуудад гарсан зөрчил дутагдлыг арилгуулахаар 2018.07.10-ны өдрийн 038-07-067/30 дугаартай Авто замын хяналтын улсын байцаагчийн албан шаардлагыг “Дорнод авто зам” ХК-д хүргүүлсэн.

Өндөрхаан-Баруун-Урт чиглэлийн 132.6 км хатуу хучилттай авто замд чанарын баталгаат хугацаанд технологийн эвдрэл гэмтэлд гарсан зөрчил дутагдлыг арилгуулах

2018.07.10-ны өдрийн 038-07-067/31 дугаартай Авто замын хяналтын улсын байцаагчийн албан шаардлагыг “Арж капитал” ХХК-д хүргүүлсэн.

A0501 дугаартай Улаанбаатар-Өндөрхаан чиглэлийн 142 км хатуу хучилттай авто замд гарсан зөрчил дутагдлыг арилгуулах 2018.07.10-ны өдрийн 038-07-067/31 дугаартай Авто замын хяналтын улсын байцаагчийн албан шаардлагыг “Багануур-АЗЗА” ТӨХК-д хүргүүлсэн.

Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2018.07.16-ны өдрийн 38-07-0901/28 дугаар удирдамжийн дагуу “Булган-АЗЗА”, “Орхон-АЗЗА”, “Сэлэнгэ-АЗЗА”, “Дархан-АЗЗА”, “Баянчандмань-АЗЗА ТӨХК-иудын санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, авто замын засвар арчлалт, ашиглалтын бэлэн байдалд хяналт шалгалтыг 2018.07.19-30-ны өдрүүдэд хийж гүйцэтгэлээ.

Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн Мөнх ерөөлт интернэйшнл ХХК-ийн Налайх дүүрэгт байрлах техникийн хяналтын үзлэгийн суурин төв нь “Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төв. Ангилал. Ерөнхий шаардлага” MNS5044:2010 стандартын шаардлага хангаж байгаа талаар дүгнэлт гаргасан.

2018 оны Усан замын тээврийн хэрэгслийн үзлэг, тооллогын ажлыг 2018.06.15-ны өдрөөс 08 дугаар сарын 01-ний өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг байгуулсан. Бэлтгэл ажил хангагдсан. Орон нутгийн радио, телевизээр мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулсан. Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн ажил хийгдэж байна.

ХОЁР. САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

2.1. Хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох талаар:

Зам, тээврийн сайдын 2012 оны 120 дугаар тушаалаар батлагдсан Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим, объект үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журмыг шинэчлэн боловсруулав.

Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх нийт 15 журмын төсөл боловсруулах ажлын явц 7 дугаар сард дараах байдалтай байна. Үүнээс 4 журам батлагдаж, 3 журам батлагдах шатандаа, 4 журам төслийг боловсруулж дууссан бөгөөд “Захиргааны ерөнхий хууль”-ийн 62.1-т заасны дагуу яамны болон холбодох веб хуудаст байршуулан олон нийтээс санал авч байна. Үлдсэн 4 журмын төслийг боловсруулах ажил хийгдэж байна.

2.2. Хууль, Шүүхийн байгууллагад төлөөлөн оролцсон ажлын талаар:

1.Тайлангийн хугацаанд Шүүхээр хэлцэгдэж байгаа 15 хэрэг маргаанаас Засгийн газрыг төлөөлж оролцож байгаа 4 хэрэг, ЗТХЯ-г төлөөлж 11 хэрэг байна. Үүнд:

- Иргэний 10 хэрэг
- Захиргааны 5 хэрэг шүүхээр хэлэлцэгдэж байна.

2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон 13 хэрэг маргаанаас Засгийн газрыг төлөөлж оролцсон **захиргааны 11 хэрэг**, Зам тээврийн хөгжлийн яамыг төлөөлж **иргэний 2 хэрэг** байна.

“Чайна гео инженеринг” ХХК-д холбогдох Зам, тээврийн хөгжлийн сайдын нэхэмжлэлтэй иргэний хэргийг шийдвэрлэсэн Анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч нэхэмжлэгч Зам, тээврийн хөгжлийн яамны зүгээс Нийслэл дэх Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасны дагуу Давж заалдах шатны шүүхийн 2018 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн шүүх хуралдаанд нэхэмжлэгч Зам, тээврийн хөгжлийн яамны итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, Зам, тээврийн хөгжлийн яамнаас 3,000.000.00 /гурван тэрбум/ төгрөг гаргуулахаар шийдвэрлэсэн Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин шийдвэрүүлэхээр буцаав.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗАРТ ТАВЬЖ ШИЙДВЭРЛҮҮЛСЭН БОЛОН ШИЙДВЭРЛҮҮЛЭХАСУУДАЛ:

Концессын гэрээгээр хэрэгжүүлэх олон улс болон улсын чанартай, тусгай зориулалтын авто замын зураг төсөл боловсруулах, барилгын ажилд хяналт тавих үйл ажиллагаанд чиглэлийн яамны оролцоог хангах шаардлагатай байгаа талаар танилцуулга, тэмдэглэлийн төсөл бэлтгэн Засгийн газрын 2018 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанд танилцуулан, 30 дугаар тэмдэглэлээр Зам, тээврийн хөгжлийн яамны оролцоог хангах заалтыг концессын, зам барилгын ажил гүйцэтгэх, зөвлөх үйлчилгээний гэрээнд тусгаж байхыг Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайханд, концессын гэрээгээр хэрэгжүүлэх авто замын төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайдад даалгасан холбогдох шийдвэрийг гаргуулсан.

“Автотээврийн салбарт төрөөс баримтлах бодлого батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөл, бодлогын баримт бичгийн төсөл, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 1-6 дугаар хавсралтуудад тусгагдах мэдээллийг боловсруулан, МУ-ын Шадар сайд Ө.Энхтүвшин, МУ-ын сайд, ЗГХЭГ-ын дарга Г.Занданшатар болон Засгийн газрын гишүүдээс санал авахаар 2018 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01/3508 дугаар албан бичгээр хүргүүлэв.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх тухай Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, тогтоолын төсөл боловсруулан Засгийн газрын гишүүдээс санал авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

Мөн Шивээхүрэн-Сэхэ боомтын төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, тогтоолын төсөл боловсруулан Засгийн газрын гишүүдээс санал авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

ДӨРӨВ. САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

4.1. Авто замын талаар:

БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн Загастайн давааны 67 км хатуу хучилттай авто замын хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр хятадын талын санал болгосон “Гуанжоу Ванан Констракшн Супервишн” ХХК-тай хэлэлцээр хийж, 2018.07.03-ны өдөр зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан.

Мөн Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто замын барилгын ажил гүйцэтгэхээр “Чайна Коммуникэйшнс Констракшн” ХХК-тай 2018.03.12-ны өдөр байгуулсан гэрээнд өөрчлөлтийг оруулах ажлын хүрээнд дээрх нэмэлтээр хийгдэх ажлын тоо хэмжээг эцэслэн гаргаж, тухайн компанитай гэрээний хэлэлцээрийг хийж, 2018.07.03-ны өдөр нэмэлт гэрээ байгуулсан. Тухайн төслийн барилгын ажлын гүйцэтгэгчтэй байгуулсан нэмэлт гэрээ болон зөвлөх компанитай байгуулсан арилжааны гэрээг Сангийн яаманд 2018.07.03-ны өдөр албан бичгийн хамт хүргүүлсэн.

Төрийн нарийн нарийн бичгийн даргын 2018 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу 2018 оны 07 дугаар сарын 20-ны өдрөөс 27-ны өдрийг хүртлэх хугацаанд Улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалт болон концессын гэрээгээр Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан аймгуудад баригдаж буй төсөл, арга хэмжээний барилгын ажлын явцтай газар дээр нь танилцаж, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэж, төсөл хэрэгжүүлэх нэгж, гүйцэтгэгч болон зөвлөхийн компанийн удирдлагуудад барилгын ажлыг эрчимжүүлэн гэрээт хугацаандаа батлагдсан зураг төслийн дагуу чанартай хийж дуусгах талаар холбогдох үүрэг даалгаврыг өгч ажилласан.

Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийн 2018 оны эхний хагас жилийн давсан орлогыг захиран зарцуулах тухай Сайдын 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 01/3291 дугаар албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн. Давсан орлогоор хийж гүйцэтгэх хөрөнгө оруулалтын ажлуудын төсөв, тооцоо, танилцуулгыг хүргүүлсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжих Сумын төвийн доторх хатуу хучилттай авто зам, 1.7 км /Архангай, Ихтамир сум/, Авто зам, гүүрийн барилга /Төв, Зуунмод сум, 2, 6 дугаар баг/, Бооржийн голын төмөр бетон гүүр /Ховд, Мөст сум/, Гэр бүл, ёслолын ордон хүртэлх авто замын гүүр, авто зогсоол /УБ, Баянгол дүүрэг/, Наадамчдын замын уулзвараас Яармагийн автобусны шинэ эцсийн буудал хүртэлх хатуу хучилттай авто зам /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/, Намирын голын төмөр бетон гүүр, авто зам /Увс, Өмнөговь сум/ зэрэг нийт 6 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, төсөв болон нарийвчилсан график төлөвлөгөөг баталж, барилгын ажлыг эхлүүлээд байна.

2018 онд шинээр эхлүүлэх дээрх төсөл, арга хэмжээний барилга угсралтын болон их засварын ажлыг гүйцэтгэх гэрээнд хариуцлагын заалтыг нарийн тусган өгч гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан бөгөөд захиалагчийн зүгээс гэрээний хэрэгжилтийг хангуулан тухайн төслийг гэрээт хугацаанд багтаан чанартай хийж гүйцэтгүүлэхээр холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Ажлын явц нь батлагдсан график төлөвлөгөөнөөс хоцрогдолтой буюу удаашралтай байгаа авто зам, гүүрийн барилгын ажлын нарийвчилсан график төлөвлөгөөг тодотгон шинэчлэн баталж, гүйцэтгэгч компани шинэчлэн батлагдсан төлөвлөгөөний дагуу барилгын ажлыг хийж гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж байна.

Гашууны голын төмөр бетон гүүрийн их засвар, 72 у/м /Увс, Улаангом сум/ гүүрийн ажлын тоо хэмжээ, зураг төсөлд өөрчлөлт оруулан 2018 оны улсын төсөвт тусгагдсан хөрөнгөнд багтаан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй цахим тендерийг 2018 оны 07 дугаар сарын 09-ний өдөр дахин зарласан.

Улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтаар болон концессын гэрээгээр хэрэгжиж байгаа авто зам, гүүрийн барилгын ажлын явц болон Олон улс, улсын чанартай авто замын бэлэн байдлын талаарх мэдээг 7 хоног бүр гарган яамны холбогдох удирдлагуудыг шуурхай мэдээллээр хангаж ажилласан.

2018 оны 07 дугаар сарын 14-17-ны өдрүүдэд нийт нутгаар хүчтэй аадар бороо орж, байгалийн онц аюултай үзэгдэл болсны улмаас нийт 14 аймгийн нутаг дэвсгэрт хамаарах 36 байрлалд нийт 173 км урт авто зам, замын байгууламжид ноцтой эвдрэл гарч тээврийн хэрэгслийн хөдөлгөөн хязгаарлагдаж зорчигчдын аюул осолгүй зорчих нөхцөл алдагдсан бөгөөд гарсан эвдрэл гэмтлийг 19-н зам хариуцагч байгууллага 184 хүн хүч, 62 машин, механизм ашиглан тухай бүрт засварлах ажлыг гүйцэтгүүлж байна.

Улсын чанартай зам хариуцагч байгууллагууд болон “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ийн хяналтын инженерүүдтэй хамтран газар дээр үзэж танилцан гарсан эвдрэлийн тоо хэмжээг тогтоон нийт төсөвт өртгийг тооцоолж, үерийн гамшгийн улмаас олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжид үүссэн эвдрэл гэмтлийг засварлах асуудлын талаар 2018 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн Улсын онцгой комиссын хуралдаанд танилцуулсан.

4.2. Автотээврийн талаар:

НҮБ-ын далайд гарцгүй, хөгжингүй орнуудад хэрэгжүүлэх “Венийн арга хэмжээний хөтөлбөр”-т тусгагдсан тогтвортой тээврийг хөгжүүлэх, худалдаа тээврийг хөнгөвчлөх чиглэлээр тусгагдсан ажлуудын хэрэгжилтийн тайланг гаргаж, тус яамны ГХАХ-т 2018 оны 07 дугаар сарын 20-нд хүргүүлэв.

Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-ын Мэдлэг Хуваалцах хөтөлбөрийн хүрээнд “БНСУ-ын Ухаалаг логистик ба тээвэрлэлт” сэдвийн дор бодлогын судалгаа хийх, логистик ба ачаа тээврийн үйл ажиллагааны ухаалаг шийдлүүдийг судлах, логистикийн чиглэлээр онолын болон практик сургалтуудыг зохион байгуулах, чадавхийг бэхжүүлэх гурван үндсэн чиглэлээр бодлогын зөвлөмж авах, бодлогын зөвлөхүүдтэй хамтран ажиллах төслийн саналыг БНСУ-ын Санхүү, стратегийн яаманд хүргүүлэхээр МУ-ын Сангийн яаманд 2018 оны 07 дугаар сарын 18-ны өдөр 03/3405 дугаар албан бичгээр хүргүүлэв.

4.3.Төмөр замын талаар:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 07 дугаар сарын 153 дугаар тушаалаар 6 ААН-д төмөр замын тусгай зөвшөөрлийг шинээр олгож 7 ААН-ийн тусгай зөвшөөрлийг сунгасан.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 159 дүгээр тушаалаар 16 ААН-ын Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагааны гэрчилгээг сунгаж, шинээр олгосон.

Монгол Улсаас ОХУ-ын Восточный боомтоор дамжуулан гуравдагч улсад бараа бүтээгдэхүүн экспортлох хүрээнд төмөр замын тээврийн тарифын хөнгөлөлт болон ачаа эргэлт зэргийг нарийвчлан судалж, судалгааг боомтуудын танилцуулгын хамт 2018 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн албан тоотоор ГХЯ-нд хүргүүлсэн.

“Төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөж буй нийт стандартуудын жагсаалтуудыг сүүлийн байдлаар гаргаж, Төмөр замын тээврийн салбарын байгууллага тус бүр “Салбарын үндэсний стандартуудад Шинжлэх ухаан, техникийн төвшинд улсын үзлэг” хийх дэд ажлын хэсгийг байгуулж, шуурхай арга хэмжээ авч

ажиллах чиглэлийг, мөн стандартуудын жагсаалт болон холбогдох материалуудыг салбарын байгууллагуудад 2018.07.17-ны 02/3398 тоот албан хүргүүлэв.

Дорноговь аймгийн Замын-Үүд суманд хэрэгжиж буй “Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх МОН-2719/0240 төсөл”-ийн хүрээнд тус төслийн Хяналт шинжилгээ, үнэлгээ болон Байгаль орчин, нийгмийн хөгжлийн үнэлгээг хийх мэргэжилтнүүдийн сонгон шалгаруулалтыг хийж сонгон шалгаруулалтын дүн, холбогдох материалыг хянуулахаар Азийн хөгжлийн банкинд 2018 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн албан бичгээр хүргүүлсэн.

4.4. Агаарын тээврийн талаар:

Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-т нэгдэн орох хуулийн төслийг УИХ-д өргөн барихтай зөвшөөрөл авах хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт 2018 оны 07 дугаар сарын 05-ны 01/3251 тоот албан бичгээр Гадаад харилцааны яам, 2018 оны 07 дугаар сарын 05-ны 01/3252 тоот албан бичгийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлээд байна.

Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын хүний нөөц, ашиглалт, менежментийн чадавхийг сайжруулах төслийн Монгол, Япон талуудын хамтарсан зохицуулах хорооны 6 дугаар хурлыг 2018 оны 7 дугаар сарын 5-ны өдөр зохион байгуулж тус хурлаар төсөл хэрэгжих хугацаанд хийж гүйцэтгэсэн ажил болон төслийн үр дүнг нэгтгэн дүгнэсэн.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 102 дугаар захирамжаар шинэчлэн байгуулсан “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэхээр санал тавьсан этгээдтэй хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсэг концессын гэрээний төслийг эхний байдлаар боловсруулан Японы консорциумд 2018 оны 7 дугаар сарын 17-ны өдөр хүргүүлсэн.

Гадаад харилцааны яамнаас 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 09/3241 тоот албан бичгээр ирүүлсэн “Нисэхийн эрэн хайх, авран туслах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг монгол хэлнээ орчуулж, саналаа холбогдох тайлбарын хамт 2018 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 03/3406 тоот албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.

ТАВ. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭ

Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ 2018 оны 7 дугаар сарын 9-ний өдөр БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайдтай хоёр талын уулзалт хийж хоёр орны зам, тээврийн салбарын хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ 2018 оны 7 дугаар сарын 23-ны өдөр БНХАУ-ын Шеньхуа группын Лү бин тэргүүтэй холбогдох төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан. Уулзалтын үеэр талууд УИХ-ын "Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг хамтран хэрэгжүүлэх, барилгын ажлыг яаралтай үргэлжлүүлэх боломжийн талаар санал солилцов.

ЗУРГАА. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан нийслэлийг аймгийн төвүүдтэй хатуу хучилттай авто замаар холбох ажлын хүрээнд хэрэгжиж буй авто зам, гүүрийн барилгын ажлыг эрчимжүүлэх, гэрээт хугацаанд багтаан ашиглалтад оруулахтай холбоотойгоор орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудаас газар түр эзэмших, түгээмэл тархацтай материал ашиглах, ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, хүлээн авахад орон нутгийн оролцоотойгоор шийдвэрлэгдэх аливаа асуудлаар зам, гүүрийн бүтээн байгуулалтын ажилд саад учруулахгүйгээр шуурхай шийдвэрлэж байх, дэмжлэг үзүүлэн ажиллахыг хүссэн албан тоотыг 2018.07.03-ны өдөр Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дархан-Уул Дорнод, Завхан, Төв, Увс, Ховд, Хөвсгөл Аймгийн Засаг Дарга нарт хүргүүлсэн.

Авто зам, гүүрийн барилга, засвар арчлалтын ажлын зохион байгуулалт, зураг төсөл, магадлалын ажлын чанар, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр тус яамны харъяа “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-тай 2018.07.06-ны өдөр уулзалт зохион байгуулсан бөгөөд тухайн уулзалтад яригдсан асуудлаар холбогдох зөвлөмжийг гарган хүргүүлж байга. Энэхүү зөвлөмжийн хүрээнд тус яам болон “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ийн харицан ажиллах ажлын чиг үүргийг тодорхой болгож, олон улс, улсын чанартай авто замын засвар арчлалтын ажлын гүйцэтгэлд хянаж баталгаажуулах, зураг төсөлд магадлал хийх, төсөл, арга хэмжээний төсвийг батлах зэрэг ажлыг “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-д шилжүүлж, хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Азийн хөгжлийн банкнаас 2018 оны 07 дугаар сарын 30-ны өдрөөс 8 дугаар сарын 06-ны өдрийг дуусталх хугацаанд “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн зээл хянах томилолтын баг ажиллахаар төлөвлөсөн бөгөөд АХБ-ны зээл хянах томилолтын багтай 2018 оны 07 дугаар сарын 30-ны өдөр томилолтын багтай танилцах, томилолтын ажлын удирдамж, чиглэлтэй танилцах уулзалтыг зохион байгуулсан.

Тус уулзалтаар төслийн хэрэгжилтийн явц байдал, төслийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудал, зээлийн хөрөнгөөс хэмнэгдэж буй хөрөнгийн зарцуулах санал болон бусад асуудлын хүрээнд хэлэлцэж, зарчмын зөвшилцөлд хүрсэн.

Мөн уулзалтаар Олон улс, улсын чанартай авто замд 11 цэгт шинээр төлбөр авах цэг болон авто пүүг барих хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлүүлэхээр болсон.

Улаанбаатар-Дархан чиглэлийн хатуу хучилттай авто замын их засвар, шинэчлэлтийн ажлын зураг төслийн хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр Сангийн яам болон Азийн хөгжлийн банкны холбогдох төлөөлөгч нартай уулзалт зохион байгуулж хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд зураг төслийг 2018 онд багтаан хийж гүйцэтгүүлэхээр шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байна.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ